



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сайншанд сумын хүүхдийн арван дөрөвдүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/140/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд 2022 он	Тэргүүлэх аудитор:	Т.Ган-Өлзий
	Утас: 70522734	Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
	Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Багийн ахлагч аудитор:	Т.Мөнхтогтох
		Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn
	Аудитор:	Д.Дэмбэрэлсүрэн
		Цахим хаяг: demberelsurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	16.8	28.8
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	207.7	213.0
	Нийт хөрөнгийн дүн	224.5	241.8
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	224.5	241.8
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	224.5	241.8
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	166.3	183.8
	Үйл ажиллагааны зардлын дүн	152.1	169.6
	Үйл ажиллагааны үр дүн	14.2	14.2
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	14.2	14.2
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	210.3	227.6
	Тайлант оны үр дүн	14.2	14.2
	Эцсийн үлдэгдэл	224.5	241.8
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	143.4	170.9
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	143.4	167.1
	Үйл ажиллагааны ЦМГ	0	3.8
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	(2.1)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	1.7
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1.7
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	164.6	164.5
	Урсгал зардал	163.9	164.5
	Хөрөнгийн зардал	2.5	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	172.7	164.5
	Улсын төсвөөс санхүүжих	165.3	164.5
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс нь “Иргэний болон эрүүгийн хэргийн талаар гарсан шийдвэр гүйцэтгэх ажиллагааг биелүүлэх” үндсэн чиг үүрэгтэй.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд 2021 оныг “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлж, албаны тухай бэлэн байдал, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх” жил болгох зорилт дэвшүүлсэн байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант онд гадаа дулааны шугамд 13.0 сая төгрөгийн засвар үйлчилгээ хийлгэж, барилга байгууламжийн дансыг тухайн дүнгээр капиталжуулж орлогот авсан байна. Мөн 2.3 сая төгрөгийн хөрөнгийг ашиглах жилийг нэмэгдүүлж орлого авсан байна.

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар дэлгэрэнгүй бүртгэл болон бусад баримт мэдээллийг шалгахад тус байгууллага нь тайлант онд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 164.5 сая төгрөгийн 36 орлогын гүйлгээ, 10 сая төгрөгийн 1 зарлагын гүйлгээ, 10.0 сая төгрөгийн 1 худалдан авах ажиллагаа, өмч хөрөнгө, төсөв зарцуулах 10 тушаал, шийдвэрийг байршуулахаас 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Аудитын явцад 1 тушаалыг нөхөж 12 сард мэдээлэв.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн тайлан, аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, худалдан авах ажиллагааны мэдээллийг шилэн дансны цахим системд хуулиар тогтоосон хугацаанд, бүрэн байршуулсан байна.

Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байхгүй байна.

Зургаа. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 6.9 сая төгрөгийн 2 алдаа зөрчил илэрснээс, 6.9 сая төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулав.

4.1 Залруулсан алдаа

1. Нэмэлт санхүүжилтийн дансны орлого 4,635,540 төгрөгийн гүйцэтгэлийг тайланд тусгахдаа санхүүжүүлсэн эдийн засгийн ангилал тус бүрээр биш бөөн дүнгээр харагдуулсан байна.
2. Ашиглах жил сунгасан 2,314,500 төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасаад буцааж орлогот авахад үнэ төлбөргүй хүлээн авсан орлого гэсэн буруу ангилалд бүртгэснийг залруулж бусад орлогот бүртгэв.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ								

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	2	6.9	2	6.9	-	-	-	-	-	-
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	2	6.9	2	6.9	-	-	-	-	-	-